Шүүгдэгч Б.Батсүх нь 2024 оны 11 дүгээр сарын 08-ны орой 22 цаг 30 минутын орчимд Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, “Шүншиг вилла” хотхоны урд замд “Тоёота Акуа” загварын 53-73 УКА улсын дугаартай тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцож явахдаа Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 15.10 “Жолооч зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ уулзварт ороод, адил замаар өөдөөс чигээрээ яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө” гэсэн заалтыг зөрчин “Кавасаки Нинжа” загварын 21-86 УАР улсын дугаартай мотоциклтэй мөргөлдөж, улмаар мотоциклийн жолооч Х.Эрдэнэсүхийн амь насыг хохироосон гэмт хэрэгт холбогдсон.